

## АГУУЛГА

<b>Удиртгал.....</b>	<b>3</b>
<b>Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн товч намтар.....</b>	<b>7</b>
<b>Чанагуух Ертөнцийн Нууц.....</b>	<b>10</b>
Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай 1992 оны б-сарын 26-ны өдөр Нью-Йорк хотноо НҮБ-д уншсан лекц	
<b>Авшиг: Гуань Инь Бясалгалын Арга.....</b>	<b>51</b>
<b>Таван Сахил .....</b>	<b>54</b>
<b>Веган хоолны ач тус.....</b>	<b>56</b>
Эрүүл мэнд ба хоол хүнс.....	57
Экологи ба хүрээлэн буй орчин .....	61
Дэлхийн өлсгөлөн .....	62
Амьтны зовлон зүдгүүр .....	62
Гэгээнтнүүд хийгээд бусад хүмүүс .....	63
Багш асуултанд хариулж байна .....	65
<b>Веганизм: Веган хоол хүнс хэрэглэх нь дэлхийг усны нөөцийн хямралаас гаргах хамгийн оновчтой арга зам мөн.....</b>	<b>76</b>
<b>Веган хоолтуудад хүргэх сайхан мэдээ.....</b>	<b>78</b>
<b>Дэлхийн өнцөг булан бүхэнд буй веган хоолны газрууд.....</b>	<b>79</b>
<b>Хэвлэл .....</b>	<b>91</b>
<b>Бидэнтэй хэрхэн холбогдох вэ.....</b>	<b>108</b>

### **Үнэгүй үлгэр дэвтэр татаж авах**

Агшин зуур билиг нээгдэхийн түлхүүр (75 хэл дээр)

<http://sb.godsdirectcontact.net/> (Формоса)

<http://www.Godsdirectcontact.org/sample/> (U.S.A.)

<http://www.direkter-kontakt-mit-gott.org/download/index.htm> (Австри)

<http://www.Godsdirectcontact.us/com/sb/>

*”Би Бүддын болон Католик шашинтны аль нь ч биш. Би Чиний харьялаидаж, Чиннийг я номлодог. Та үүний Бүддын шашин, Католик шашин, Бүмбүн шашин гэх юмуу аль хүссэнээрээ я нэрлэ. Би бүгдийг нь дуртайга хүмээн авна.“*

~Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай~

*”Дотоод амар амарлиниүйгээ олж авснаар бид бусад бүх зүйлийг олж авна. Сэтиэнийн бүрэн ханамж, тэнциэрлэг диваажин болоод газар дэлхийн хүсэл бүхэн билэх нь бидний мөнхийн нийцэл зохицол, мөнхийн билүүн ухаан, хамиийг чадаиг хүчиний дотоод ухаарагчий болох Эзэн Бурханы орноос ирдэг юм. Энэ бүхнээ эс олбоос бид хэчинээн их мөнгө хөрөнгө, эрх мэдэлтэй, нийтийн хэчинээн өндөр байр суурьттай байлаа ч гэсэн хэзээ ч сэтиэл ханиалуун болж чадахгүй“*

~Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай~

*”Сургаал маань та энэ дэлхий дээр юу я хийх ёстой байна, түүнийгээ хий. Хамаи зүрх сэтиэнийнхээ уяас хий. Хариуцаатай байж, үүнийхээ зэрэвцээ өдөр бүр бясалал хий үзэлтийг оришино. Та өөртөө болон дэлхий өртөнцөд үйлчлэхийн түүдд үлам их эрдэм мэдлэг, үлам их билүүн ухаан, үлам их амар амарлиниүйг олж авах болно. Таны дотоор өөрийн тань сайн сайхан чанар ориши бүйг бүг март. Бие маходод тань Эзэн Бурхан ориши бүйг бүг март. Зүрх сэтиэл тань Бүдда ориши бүйг бүг март.“*

~Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай~

## УДИРТГАЛ

**X**үн төрөлхтний сүнсний хөгжлийг дээшлүүлэх явдал цорын ганц үүрэг зорилго нь болсон ховор нандин хүмүүс үе үеийн туршид бидний дунд төрж байжээ. Бурхан Шагжмуни, Мухамед болоод Есүс Христ ч бас тийм л хүмүүс байсан юм. Энэ гурвыг бид сайн мэддэг хэдий ч бас бид нэрийг нь сонсоогүй өөр олон хүн байжээ. Зарим нэг нь хүмүүст сургаал номлолоо айлдаж байсан тул тэдгээр хэдэн хүн нь л мэддэг байж, харин бусдынх нь нэр мэдэгдэлгүй үлджээ. Тэднийг янз бүрийн улс оронд, янз бүрийн цаг үед өөр өөрөөр нэрлэж байв. Хүмүүс тэднийг Багш, Хувилгаан, Гэгээнтэн, Аврагч, Мессей, Ариун Эх Дагина, Элч, Гүрү, Амьд Гэгээнтэн зэргээр нэрлэж иржээ. Тэд Гэгээрэл, Аврал, Төгөлдөржилт, Чөлөөлөлт буюу Сэхээрэлт гэгддэг тэрхүү зүйлийг бидэнд зааж сургах гэж л ирсэн. Хэдийгээр энэ зүйлийг нэрлэж байгаа үгс нь ялгаатай ч уг чанартай утга санаа нь нэг ижил юм.

Урьд үеийн гэгээнтнүүдтэй адил Тэнгэрлэг Эх Сурвалжаас ирсэн, оюун санааны асар их хүчтэй, ёс суртахууны цэвэр ариун чанартай, хүн төрөлхтнийг сэхээрүүлэх хүч чадал бүхий Зочид өнөөдөр бидний дунд оршин буй атал тэдний талаар тун цөөхөн хүн л мэдэж байна. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай бол тийм гэгээнтнүүдийн нэг юм.

Амьд Гэгээнтэн гэж шүтэгддэг хүмүүстэй Чин Хай Багш адилгүй тул тийн хүлээн зөвшөөрөхөд амаргүй. Учир нь тэр бол эмэгтэй хүн. Буддын шашинт болон өөр бусад олон хүн эмэгтэй хүн Будда болж чадахгүй гэдэг үлгэрт итгэдэг. Мөн Тэр бол Дорнын гаралтай хүн, харин Өрнийн хүмүүс Аврагчаа өөрсөдтэйгээ адилхан байгаасай хэмээн хүсдэг. Гэвч Түүнийг таних боломж олдож, сургаал номлолыг нь дагасан дэлхийн өнцөг булан бүрийн, олон янзын шашинтай шавь бид Түүний чухам хэн болохыг нь мэднэ. Та таньж мэдье гэвэл оюун ухаанаа зохих хэмжээнд нээлттэй байлган, чин сэтгэлээсээ хандаж, тодорхой хэмжээний цаг зав болон анхаарлаа зориулахаас өөр зүйл хэрэггүй.

Хүмүүс ихэнх цагаа амь зуух мөнгө олох болон материаллаг хэрэгцээндээ санаа тавихад зарцуулдаг. Бид өөрийн амьдрал болоод хайрлаж хүндэлж явдаг хүмүүсийнхээ амьдралыг аль болох тав тухтай болгохын төлөө ажилладаг. Чөлөө цаг

гарах үед улс төр, спорт, телевиз болон хамгийн сүүлийн үеийн дуулиан шуугиан, хов жив гэх мэт зүйл руу анхаарлаа хандуулна. Бурхантай дотооддоо шууд холбогдож, хайрын хүчийг ойлгож таньсан зарим маань харин амьдралд үүнээс илүү зүйл гэж байдгийг мэддэг. Энэ сайхан мэдээ өргөн олон түмэнд хүрдэггүй нь бидэнд тун харамсалтай санагддаг юм. Амьдралын төлөөх бүхий л зүтгэл тэмцлийн шийдэл нь дотоодод маань анир чимээгүй оршиж, хүлээж байдаг. Диваажин гар сунгах төдий зайд оршдог гэдгийг бид мэднэ. Бид хэт их итгэл үнэмшлээсээ болж зохисгүй загнаж, ухааныг тань цочроосон зүйл хэлсэн бол өршөөнө үү. Мэдсэнээ мэдээд, харснаа хараад чимээгүй суугаад байх нь бидэнд хэцүү байна.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн шавь, Түүний уламжилсан Арьяабалын номын цогц буюу дотоодын гэрэл аялгуу ажих бясалгалын номын ахан дүүс бидний зүгээс манай Багш болон өөр Багш нараар дамжин биеллээ олж болох Диваажинг Ухаарах ахуй ойлголтонд тань дөхөм болох болов уу хэмээн найдаж энэхүү танилцуулах номыг танд өргөн барьж байна.

Их Багш Чин Хай бясалгал, дотоод төвлөрөл, залбирлын ач холбогдлыг заан сургадаг юм. Бид энэ насаа үнэхээр аз жаргалтай өнгөрүүльье гэвэл өөрийн дотоод Бурхан Чанараа нээн илрүүлэх ёстой юм хэмээн тэр тайлбарладаг. Тэрбээр Гэгээрэл гэдэг бол тийм ч хүрэхийн аргагүй нууц далд, сонгомол хэсэг хүн эсвэл зөвхөн дияланч нар л хүрч болдог зүйл биш гэдэг юм. Багшийн маань үүрэг бол биднийг ердийнхөөрөө амьдарч байхад дотоодын маань Бурхан Чанарыг дуудан сэрээх явдал юм. Багш маань: **Бид цөм Үнэн Ёсыг мэднэ. Бид ердөө л мартчихсан юм. Тэгээд зарим үед бидний амьдралын зорилго юу юм, яагаад Үнэнийг эрж олох ёстой юм, яагаад бясалгал хийх хэрэгтэй юм, яагаад Эзэн Бурхан болоод Будда, Ертөнцийн Хамгийн Дээд Хүч гэгдэх нэгэнд итгэх ёстой юм гэдгийг бидэнд сануулах гэж хэн нэгэн хүн заавал ирэх ёстой болдог юм** гэжээ. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай өөрийг нь шүтэн дагахыг хэнээс ч хүсээгүй. Тэрбээр бусад хүн өөрийнх нь гэгээрлээс жишээ аван өөрсдөө Эцсийн Чөлөөлөлтөнд хүрэхийг л ердөө санал болгодог.

Энэ товхимол бол Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай-н сургаалын удиртгал болно. Энэ товхимолд орсон Чин Хай Багшийн ном тайлж хэлсэн үг, эргэцүүлэл тайлбар, иш татаж ярьсан зүйл нь дуу хураагуураар бичиж аваад цаасанд

буулгасан, заримдаа өөр хэлнээс орчуулж дараа нь хэвлэх гэж хянан тохиолдуулсан зүйл гэдгийг анхаарна уу. Бид танд аудио болон видео эх хуурцгийг үзэж, сонсоорой гэж зөвлөж байна. Ингэх нь хэвлэмэл үсгийг бодвол Тэр өөрөө биеэрээ бодитой байгаа юм шиг илүү тод мэдрэмж төрүүлэх болно. Түүнтэй биечлэн уулзаж, нүдээрээ үзэх нь бүр ч илүү ойлголт өгөх нь мэдээж.

Чин Хай Багш зарим хүнд Ээж нь, зарим хүнд Эцэг нь, заримынх нь хувьд Хайрт хүн нь болдог юм. Хамгийн наад зах нь Тэр энэ ертөнц дээр олдож болох хамгийн сайн Найз тань байх болно. Тэр энд бидэнд өгөх гэж ирснээс биш авах гэж ирээгүй. Тэрээр сургаал ном айлдаж, дэмжиж тусалсан болон авшиг хүртээснийхээ төлөө ямар ч төлбөр авдаггүй. Тэр зөвхөн зовлон зүдгүүр, уйтгар гуниг, зовиур шаналлыг тань л авах болно. Гэхдээ зөвхөн Та л өөрөө хүсч байвал шүү дээ!

## Товч Илгээлт

**Э**зэн Бурхан болоод Дээд Эрхэм Сүнсний тухай ярихдаа Их Багш Бурхан эр эсвэл эм хүйстэй алийн болох маргаанаас зайлсхийж, хүйсний ялгаа заадаггүй оригинал нэр томъёо хэрэглэж байхыг бидэнд заадаг юм.

She+He= Hes (Bless гэдэгтэй адил дуудна.)

Her+Him=Hirm (Firm гэдэгтэй адил дуудна.)

Hers+His=Hiers (Dear гэдэгтэй адил дуудна.)

Жишээлбэл: Эзэн Бурхан хийх болохоороо Тэрээр (Hes) юмыг Өөрийнх нь (Hirmself), Түүний (Hiers) хүсэл зоригт нийцэж тохирч байхуйцаар хийдэг юм.

\***Ү**ран бүтээлч, сүнслэг бясалгалын багш болох Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай дотоод гоо сайхны аливаа илэрхийлэлд дуртай. Иймээс нь Тэрбээр Вьетнамыг “Ау Лак”, Тайванийг “Формоса” хэмээн өгүүлдэг. Ау Лак гэдэг нь “Аз жаргал” гэсэн утгатай Вьетнамын эртний нэр юм. “Үзэсгэлэнтэй” гэсэн утгатай Формаса хэмээх нэр нь энэ араг болон хүн ардынх нь гоо сайхныг илүү төгс төгөлдөр илэрхийлдэг. Энэ нэрсийг хэрэглэх нь энэ нутаг орон хийгээд оршин суугчдад нь сүнслэг хөгжил дэвшил, аз хийморь авчирдгийг Их Багш мэддэг юм.

*"Баши үэдэй бол таныг Баши болиж... та өөрийнөө Баши үэдийг мэдэж, Эзэн Бурхан болон та нэг юм үэдийг ойлюхад тань тусалж чадах түүхүүртэй хүн юм. Ердөө л энэ. Энэ бол Башийн цорын таниг зорилго юм."*

~Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай~

*"Манай зам мөр бол шашин биш. Би хэнийг ч Католицизм юм уу Буддизм эсвэл өөр ямар нээн "-изм" рүү хандуулж чадац. Би зөвхөн танд өөрийнөө таныг мэдэх, хаанаас ирснээ олж мэдэх, газар дэлхий дээрх үүрэг зорилгоо сэргээн санах, ертөнчийн нууцыг нэх, ягаад ийм их зөвлөн зүйлүүр оршиж байдаг болон үхлийн дараа биднийг юу хүрээж байдшийг ойлюх зам мөрийг санал болиж байгаа юм."*

~Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай~

*"Бид үэндүү гарв чөлөөтийг байдаасаа болоод Эзэн Бурханаас туслаарлаиджээ. Хэн нээн хүнтэй ярилжаж байхад утас тань дугараад байдаг. Та хоолоо хийгээд юм уу эсвэл өөр хүүхүүстэй яриад гарвигийг байх юм бол хэн ч танигтай холбоидож чадахийг. Эзэн Бурхантай холбоодохын хувьд ч бас ийм л юм болдои. Тэр бидэн рүү өдөр бүр замгаач бидэнд Түүнд зориулж цай гарв байдаигийг түүл Түүнд хариу өвлийг утсаа тасалсаар байдаг билээ."*

~Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай~

## ТӨГС ГЭГЭЭРСЭН ЧИН ХАЙ БАГШИЙН ТОВЧ НАМТАР

**И**х Багш Чин Хай Ау Лакт нэгэн чинээлэг гэр бүлд нэр хүндтэй ардын оточ хүний охин болон мэндэлжээ. Тэрээр Католик шашинтын ёсоор өсч хүмүүжсэн боловч эмэг эхээсээ Буддын шашны гол үндэс, ойлголтуудыг олж мэджээ. Хүүхэд ахуйдаа шашны сургаал номлол, гүн ухааныг ихэд сонирхдог байсан төдийгүй аливаа амьтныг гойд хайрлан энэрдэг байжээ.

Арван найман настайдаа Их Багш Чин Хай Англи руу суралцахаар явж, хожим нь Францад тэгээд Германд очиж, Улаан Загалмайн нийгэмлэгт ажиллан нэгэн Герман эрдэмтэнтэй гэрлэжээ. Гэр бүл болон хоёр жил аз жаргалтай амьдарсныхаа дараа Тэрбээр нөхөртэйгөө зөвшилцөн тохиролцсоноор гэрээ орхиж, гэгээрлийг эрэл хайгуулд гарчээ. Ийнхүү тэрбээр бага наснаасаа мөрөөдөн тэмүүлсэн хүсэл зорилгоо гүйцэлдүүлэх боломжтой болсон байна. Тэр үед өөрт олдсон хэн нэгэн Багш болон гэгээрсэн Багш нарын удирдлага дор олон янзын бясалгаль дадал болоод оюун санааны дэг горимд суралцаж байв. Тэрбээр хүн төрөлхтний зовлон зүдгүүрт ганц хүний тус нэмэр гавихгүй зүйл болохыг ойлгоод хүнд туслах хамгийн сайн арга бол өөрөө өөрийгөө бүрэн таньж мэдэх явдал гэдгийг ухаарчээ. Дан ганц энэ л зорилго өвөрлөж, төгс гэгээрэлд хүргэх аргыг эрэн хайж, олон олон улс орныг тойрон аялав. Олон жилийн сорилт туршилт, зовлон зүдгүүрийг даван туулсны эцэст нь Их Багш Чин Хай Гималайн ууланд Арьяабалын бясалгалын арга, түүний Бурханлаг Дамжуулалт авшигийг хүртжээ. Тэрээр авшиг хүртсэнийхээ дараа Гималайн ууланд дияланчлан сууж, хэсэг хугацаагаар хичээнгүйлэн бясалгасны дараа төгс гэгээрэлд хүрсэн билээ.

Гэгээрснийхээ дараа хэдэн жилийн турш Их Багш Буддын гэлэнмаа болж эгэл даруу, нам гүм амьдарч байв. Их Багш угийн бүрэг даруу хүн бөгөөд хүмүүс ном зааж, авшиг хүртээхүйг

эрэн ирэх хүртэл энэ Эрдмээ нууцалсаар байжээ. Америк, Формаса дахь анхны шавь нарынхаа шаргуу идэвх чармайлт, чин сэтгэлийн хүсэлт гүйлтаар Их Багш Чин Хай дэлхий даяар лекц яриа хийж, чин сэтгэлт оюун санааны эрэлчин хэдэн арван мянган хүнд сэтгэлийн авшиг хүртээжээ.

Өнөөдөр янз янзын шашин шүтлэгтэй, өөр өөр улс орны Үнэн Мөрийг эрэгч олон олон хүн хамгийн төгс төгөлдөр билиг ухааныг нь олж хүртэх гэж Их Багш Чин Хайруу тэмүүлж байна. Арьяабалын бясалгалын арга - хамгийн төгс дээд ганц нь хэмээн Өөрийн биеэр нотолсон агшин зуур гэгээрэх энэ аргаар нь бясалгаж, үүнд суралцахыг чин сэтгэлээсээ хүсэгч хэн бүхэнд Их Багш Чин Хай авшиг хүртээж, оюун санааны зам мөртцаашид замчлан дагуулахад бэлэн байдаг юм.

Ертөнц зөвлөнд автсаад  
Ердөө би л таныгаа үнэм!  
Хэрэв та ертөнцийн дотоодод байх аваас  
Хамаиг зөвлөн аяндаа зайлсан одмуй.  
Тэйлээ ч, орчон зөвлөнд автсан болохоор  
Тандын зориулалтадаа хайгаад олохийг нь, би!



Харцны тань сайхнаас үанцагт ч агуулж хүртэхийн төлөө  
Хан ертөнцийн хамаиг л од, наран, саран ч  
худалдаж орхихсон, би  
Аа, Цаглаашүй Үзэрэлт Батши минь!  
Ашигн зүүр үзрэээрээ энэлсэн зүрхийг минь ишүүлж,  
нишүүлсэн соёрх!



Ертөнцийн эзлэхэн үэрэл, энүүхэн азлиүүн доор  
Ертөнцийн хүмүүс үзэши дүүлан бүжихээр одмуй.  
Сэлүүн аниргийд би л орь үанцаар суугаад  
Сэйтээнийн доторх үэрэл, азлиүүнаа найтан танхнам.



Төөвлөр өрхэмийн тань таньнаас хойш, Эзж бурхан минь  
Тоост хорвооийн юухныг ч үсэн тоохое болсоон, би  
Тэнцэрлэг Хайр Энэрэлдээ л тэвэрч хайрла, намайг  
Үүрд!

Аминь.



~ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай ~  
“Чимээгүй нулимс” шүлгийн түүврээс

## ЧАНАГУУХ ЕРТӨНЦИЙН НУУЦ

**Төгс Гэгээрсэн Их Багш ЧИН ХАЙ  
1992 оны 6-сарын 26-ны өдөр, (DVD№ 260)  
Нью-Йорк хотноо НҮБ-д уншсан лекц,**

**Н**эгдсэн Үндэстний Байгууллагад тавтай морилцгооно уу. Одоо хүн бүр өөрийн шүтлэг бишрэлээрээ, өөртөө байгаа бүхний төлөө, энэ бүхнийг бидэнд өгснийх нь төлөө Эзэн Бурханд талархан, хамтдаа жаахан залбиран даатгая. Мөн гачигдаж дутагдаж буй хүмүүс хүссэн бүхнээ бидний адил хүртэх болтугай; даян дэлхийн дүрвэгсэд, дайн дажны хөлд нэрвэгдэгсэд, цэрэг дайчид, төр засгийн тэргүүн нар, түүнчлэн НҮБ-ын удирдагчид санаж бодсон бүхнээ гүйцээж чадаад бие биетэйгээ эв найртай амьдрах болтугай гэж сэтгэл зүрхнийхээ угаас хүсэн ерөөж, итгэж найдья.

Хүсч гүйсан бүхэн маань биелнэ гэдэгт бид итгэж байна. Яагаад гэвэл Библид ингэж өгүүлсэн байдаг билээ. Баярлалаа.

Та бүхний мэдэж байгаачлан өнөөдрийн лекцийн сэдэв бол “Чанагуух ертөнц”. Учир нь та нарын мэдэх энэ ертөнцийн тухай та бүхэнд илүү юм ярья гэж надад бодогдохгүй байна. Энэ ертөнцийн чанадад бол харин огт өөр зүйлс байдаг. Энд ирсэн бүх хүмүүс энэ тухай сонсож мэдэх сонирхолтой байгаа болов уу. Энэ бүхэн бол манай бясалгагч сая та наарт хэлсэн шиг итгэхүйээ бэрх уран сэтгэмж юм уу ид шидийн зүйл биш. Энэ бол маш шинжлэх ухаанлаг, учир зүйд бүрэн дүүрэн нийцэх атлаа нэн чухал зүйл.

Шашны янз бүрийн бичиг зохиол хийгээд Ариун судруудад тэнгэрийн долоон орон, ухамсын өөр өөр түвшин, бидний дотоодод байх Бурханы орон, Бурхан чанар... зэрэг нь оршин байдаг тухай дурдсан байдгийг бид бүгд сонсож байсан. Эд бүхэн бол энэ ертөнцийн чанадад байдаг хэмээх зүйлс юм. Гэвч эдгээр Ариун сударт амласан тэр зүйлст тийм ч олон хүн хүрч чаддаггүй. Олон биш шүү. Ер хэн ч хүрч чаддаггүй гэж

хэлж болохгүй боловч тийм ч олон хүн хүрдэггүй. Дэлхийн хүн амын тоотой харьцуулбал дотоодынхоо Бурханы оронд буюу “Чанагуух ертөнц” гэгддэг тэр зүйлд хүрсэн хүн үнэндээ маш цөөхөн.

Хэрвээ та Америкт амьдардаг бол та бүхэнд чанагуух ертөнцөд байдаг зүйлсийг дүрсэлсэн өдий төдий ном унших боломж байдаг биз. Мөн америкичуудын хийсэн киноны зарим нь тэр чигтээ сэтгэлдээ ургуулсан, зохиомол зүйл ч биш. Япончуудын хийсэн кинонууд ч зөвхөн уран зохиол биш. Учир нь тэдгээр найруулагч чанагуух ертөнцөд очиж үзсэн хүний бичсэн номыг уншсан, эсвэл тэд өөрсдөө Бурханы гэрэл гэгээнд нэвтэрсэн байх магадлалтай.

За тэгэхээр, Бурханы оронд ер нь юу байдаг хэрэг вэ? Бидэнд энэ ертөнцийн өдий төдий хэрэг явдал, ажил төрөл, тав тухтай оронгэр, элгэмсэг дотно хүмүүс байсаар байтал юунд Бурханы орны тухай санаагаа зовоох ёстой вэ? Чухамдаа гэвэл бидэнд энэ бүхэн аль хэдийнээ байгаа учраас л бид Бурханы орны тухай бodoх хэрэгтэй байгаа юм. Бурханы орон гэж ярихаар – энэ үг дэндуү шашиналг сонсогддог. Гэтэл энэ бол үнэн хэрэгтээ дээд ухамсын нэг түвшин төдий юм. Эрт цагт хүмүүс үүнийг диваажин гэдэг байв. Шинжлэх ухааны нэр томьёогоор бол үүнийг мэдлэгийн өөр үлэмж дээд түвшин, билиг ухааны илүү өндөр дээд шат гэж тодорхойлж болно. Тийм болохоор хэрхэн яах арга замыг мэдчихвэл бид ч үүнд хүрч чадна.

Саяхан Америкт нэгэн шинэ бүтээл гарч, хүнийг самадид оруулж чадах машин бий болж гэж бид бүгд сонсов. Та бүхэн хэрэглэж үзэв үү? Үгүй юу? Америкт бол энэ нь маш хямдхан, та самадийн аль түвшинд орохыг хүсч буйгаас хамаараад дөрвөн зуугаас долоон зуун долларын үнэтэй. Хүмүүсийн ярих нь, энэ машиныг бясалгал хийх дургүй мөртлөө нэн түргэн самади агуулах санаатай залхуу хүмүүст зориулсан аж. Энэ тухай та нар мэдэхгүй байгаа бол би товчхон ярьж өгье.

Энэ машин хүнийг тайвшуулан сулруулж, уураг тархийг нь амрааж чаддаг, тэгээд I.Q (юуны итгэлцүүр) нь өндөр түвшинд хүрдэг гэж байна. Энэ нь хүнд дээд зэргийн эрдэм мэдлэг, дээд зэргийн билиг ухаан өгдөг, тэр хүнд гайхалтай сайхан байгаа мэдрэмж төрдөг гэнэ. Энэ машинд тусгайлан сонгосон

гадна талын хөгжим ашигладаг болохоор та заавал чихэвч зүүх хэрэгтэй болно. Тэгээд тэд өөрийг тань өдөөх цахилгаан, гүйдэл маягийн юм өгөх ба тэгмэгц та гэрэл гялбаа мэт ямар нэг зүйл үзнэ. Тиймээс нүдээ заавал боох шаардлагатай. Самади агуултая гэвэл нүдээ боож, чихэвч зүучихвэл гүйцэх нь тэр. Энэ маш сайхан хэрэг, тэгээд бас дөрвөн зуун доллар төдийхөн, маш хямдхан байгаа биш үү. Гэтэл бидний самади бол үүнээс ч хямд, сохор зоос ч хэрэглэхгүй, тэгээд бас үүрд мөнхийнх байдаг. Түүнчлэн цахилгаан зайнаас цэнэглэх, залгуурт залгах, салгах хэрэггүй эсвэл машин ажиллахгүй бол засах ч шаардлага байхгүй билээ. Тэгэхээр, зохиомол гэрэл гялбаа, дуу аялгуу хүртэл хүнийг амирлуулан тайвшруулж, билиг ухааныг нь нээгдүүлж чаддаг-ийм зүйлс өгөх ёстой гэнэ. Би энэ тухай сониноос уншсанаас биш өөрөө хэрэглэж үзээгүй. Тийм учраас энэ юм маш их дэлгэрч байгаа бөгөөд бас борлуулалт сайн байгаа гэж дуулдаж байна. Ийм хиймэл зүйлс хүртэл сэтгэлийг амар тайван болгож, оюуны итгэлцүүрийг (I.Q) маань дээшлүүлж чадаж байхад жинхэнэ үнэн бодит зүйл бидний билиг ухаанд хэчинээн их тус болж чадахыг төсөөлөөд үз! Жинхэнэ үнэн зүйлс нь хэдийгээр энэ ертөнцийн чанадад байдаг ч холбогдохыг хүссэн хэн ч хүрч болохуйц зүйл юм. Энэ бол дотоодын тэнгэрлэг Хөгжим, дотоодын тэнгэрлэг Аялгуу юм. Энэ Эгшиг хөгжим..., дотоодын Гэрэл гэгээ болон дотоодын Дуу Аялгууны хүчний түвшнээс хамааран бид өөрийгөө энэ ертөнцийн зааг хязгаараас түлхэн гаргаж, үлэмжийн гүн гүнзгийг ухамсрын түвшинд очиж чадна.

Үүнийг би физикийн хуультай адилхан гэж боддог. Газрын татах хүчний эсрэг... пуужин хөөргөө гэвэл пуужинг асар их хүчээр түлхэх хэрэгтэй бөгөөд түүний хурд нэн их болох үед пуужин гэрэл цацуулна. Тэгэхээр чанагуух ертөнцүү маш их хурдтай нисэх үедээ бид ч бас... Гэрэл гэгээ цацуулна, мөн түүнчлэн бид Дуу аялгуу ч сонсож чадна.

Энэ Аялгуу бол биднийг дээд түвшин рүү түлхэж буй Хэлбэлзлийн Хүчний нэг төрөл. Гэхдээ ямар ч дуу чимээ гаргалгүй, нэг их түвэг удалгүй, тохь тух алдуулалгүй, зардал мөнгө ч шаардалгүйгээр “үүнийгээ” хийдэг юм. Энэ бол чанагуух ертөнцөд хүрэх арга зам мөн.